



ЗАВХАН АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А/57

Улиастай

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгах, нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.18, 15 дугаар зүйлийн 15.1.4, 16 дугаар зүйлийн 16.7, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2, 1.1 дэхь заалт, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 11р сарын 03-ны өдрийн “Журам шинэчлэн батлах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” А/383 дугаар тушаал, 2022 оны 9-р сарын 27-ны өдрийн “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/480 дугаар тушаал, аймгийн Засвар даргын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Б/54 дүгээр захирамж, Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгах байгууллагуудын нэрсийг нэгдүгээр, тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах байгууллагыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Тусгай зөвшөөрөлийн хугацааг сунгасан байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэлтэс (Ө.Уранчимэг)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Т.Цолмонбаатар)-т даалгасугай.

ДАРГА



М.ҮРЖИНХАНД


202300000325

Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 12
дугаар сарын 26 өдрийн А.А.А дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААГ СУНГАХ БАЙГУУЛЛАГА

№	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрлийн сунгасан хугацаа	Тусгай зөвшөөрлийн дуусах огноо	Тусгай зөвшөөрлийг сунгасан огноо
1	Шилүүстэй эрүүл мэндийн төв	5 жил	2024.01.19	2029.01.19
2.	Хан -түшиг-уянга ХХК-ний эмийн сан	5 жил	2024.01.19	2029.01.19
3.	Тэгшдэлгэрэх ХХК-ний эмийн сан	5 жил	2023.11.24	2028.11.24
4.	Шидэт үрэл ХХК-ний эмийн сан	5 жил	2023-12-26	2028.12.26
5.	Маргазхан ХХК-ний эмийн сан	5 жил	2023-12-26	2028.12.26
6	Үе залгамжлагч-элит ХХК-ний шүдний эмнэлэг	5 жил	2024.01.19	2029.01.19

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 12
дугаар сарын 26 өдрийн А/57 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ БАЙГУУЛЛАГА

№	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрлийн нэмэлт өөрчлөлт	Тусгай зөвшөөрлийн эхлэсэн огноо	Тусгай зөвшөөрлийн дуусах хугацаа
1	Одчим наран ХХК-ний "Одчим наран ортой эмнэлэг"	Мэдрэл, дотор, лаборатори гэснийг (Клиник) болгон өөрчлөх	2021.06.17	2026.06.17

-oOo-